

ТҮҮХ, ОРЧИН  
ҮЕ

МОНГОЛ-НИРУН УЛСЫН (330 ОРЧИМ  
-555 ОН) АЖ АХУЙ

Г. Сүхбаатар

Монгол-Нирун улсын аж ахуйн тухай хятад сурвалж бичгийн нэлээд, хомс, мэдээг нягтлан үзэхэд нирунчуудын аж ахуйн ерөнхий байдал тодорхой харагдаж байна. Нирунчуудын тухайд археологийн олдворыг одоохондоо илрүүлэн тогтоож чадаагүй байгаа болохоор сурвалж бичгийн мэдээнд тулгуурлав.

**Нүүдэллэх байдал.** Нирунчууд өвс, ус даган нүүдэллэн, мал аж ахуй эрхэлдэг. Нүүхдээ зөөж байдаг эсгий гэрт суудаг тэдний нутаг зун цас тогтдог өндөр уулстай, олон мянган газар үргэлжилсэн нүд алдам тал газартай (10-ын 4, 6, 39, 43; 16-ын 267, 269, 289) гэж сурвалж бичигт нүүдэлчид мөн болохыг цохон тэмдэглэсэн байна. Нирунчууд нүүдэллэх байдал нь монголын түрүү ба хожуу үеийн нүүдэлчдийнхтэй адил байна.

Тэд зун говиос урагш зусна, өвөл говиос хойш гарч өвөлжинө. (10-ын 4, 6; 16-ын 267, 269) гэж сурвалж бичигт тэмдэглэснээс үзэхэд Монгол орны нүүдэлчид нэн эрт үеэс эхлэн говь, хангай, хээр тал хосолсон монгол нутагт уртрагийн чиглэлээр улирлын байдал даган нүүдэллэдэг байсан бололтой.

Монгол ардын хувьсгалаас өмнө манай орны засаг захиргааны гол том нэгж болох аймаг уртраг дагууд хуваасан нутагтай байсан. Тийм хуваарь таван хошуу малыг улирлын байдлаар бэлчээрлүүлэхэд захиргааны хуваарийн садааг нэг талаар арилгасан хэрэг. Цаашилбал, нируны нутгийн тал газар ногоон өвсгүй, цаг улирал хүйтэн, адуу, үхэр хатсан өвс, цастай иддэг боловч, угаасаа тарган, тартай байдаг (10-ын 39; 16-ын 289) гэж сурвалж бичигт тэмдэглэсэн нь нируны мал дотор ерөнхийдөө ган зудад тэсвэртэй дархан мал байсны гэрч байх гэж бодно. Ер нь ХХ зууны эхний үеийн манай орны малчдын мал маллагааны туршлагаас үзэхэд малын сүрэг дотор зуд мэтийг дааж чадахуйц хур тарган дархан мал нэлээд олон байдаг байсан.

**Малын тоо.** Нирунчуудын малын нийт тоог дурьдсан баримт сурвалж бичигт байхгүй. Гэвч табгачийн Вэй улсын цэрэг Монгол-Нирун улсыг үе үе довтолон, асар олон мал дээрэмдэж байсан тухай мэдээнээс үзэхэд Нирунчууд нэг талаар олон малтай байсан, нөгөө талаар малын толгойн тоо нь ерөнхийдөө тогтвортой байсан гэж үзэж болмоор санагдана. 385 онд Нируны Кужэний дүү Цзюань Нируны өөр аймгийн толгойлогч Цзыво-г Ньюцюань голоос хойш орших Ицинь шань (Исиньшань) ууланд довтолон цохиж, хэдэн буман үхэр, хонь олзолсон байна. (10-ын 77). 449 оны 9-р сард Нируны довтолсон табгачийн гурван замын цэрэг Нируны нэг сая гаруй малыг дээрэмдэн аваачсан. (10-ын 17; 16-ын 276). 547 онд Баруун Вэй улс Нируны хоёр түмэн тэмээ, адуу үхэр, хонийг олзолсон юм. (10-ын 245). Баруун Вэй улс 554 онд 4-р сард Нируныг довтолон төрөл бүрийн мал хэдэн түмийг

дээрэмдсэн байна. (10-ын 256). 555 оны 7-р сард Умард Ци улсын хаан Вэнь Сюань Нируны үхэр, хонь хэдэн бумыг дээрэмдсэн байна. (10-ын 258—259). Эл дурдсан 170 жилийг хамарсан таван баримтаас үзэхэд:

а) Нирунаас олзлогдсон мал хэдэн түмээс нэг сая толгой хүрч байгаа нь Нирунчууд олон сая малтай байсныг тойм төдий ч гэсэн хамруулж байна;

б) энэ 170 жилийн дотор олзолсон малын тоо ерөнхийдөө тогтмол байгаа нь нируны малын тоо харьцангуй тогтвортой байсны барагцаа шинж;

в) тэмээ, адуу, үхэр, хонь дурдагдаж байгаа болохоор нирунчууд таван хошуу малтай байсан байна.

**Сүргийн бүрэлдэхүүн.** Нируны сүргийн бүрэлдэхүүн гэвэл хамгийн олон нь бог мал (хонь, ямаа), дараа нь адуу, үхэр, хамгийн цөөн нь тэмээ байсан байна. 547 онд олзлогдсон хоёр түмэн мал дотор тэмээ дурдагдаж байгаагаас гадна 538 онд Баруун Бэй улсын хааны хатан болсон, Нируны хаан Анагуйн охины инжинд мянган толгой тэмээ өгч байснаас (10-ын 50) үзэхэд тэмээ барагцаалбал хэдэн түм байсан байна. Анагуй хаан өөрийнхөө сүрэгт түм буюу хэдэн мянган тэмээтэй байж охиныхоо инжинд мянган тэмээ өгч чадах байсан нь мэдээж. Бог мал дийлэнхи олон нь байсан нь эргэлзээгүй. Харин ямаа дурьдагдахгүй байгаа нь нүүдэлчдэд хонь, ямаа хоёр нэг сүрэг болж байдагтай холбоотой. Адуу, үхэр хоёрын алин нь илүү олон байсныг тодорхой хэлэхэд бэрхтэй. Адуу ердийн гол унаа болдгийн зэрэгцээ цэргийн агт байдгийн хувьд сурвалж бичигт маш олон удаа дурьдагдсан. Морь 407—541 оны хооронд сурвалж бичигт дангаараа 11 удаа дурьдагдсан нь аж ахуйгаас гадна цэргийн стратегийн холбогдолтой байсныг харуулж байна. 407 онд Шэлунь хаан хожуу Цинь улсын хаан Яо Синд 8000 адуу бэлэглэхээр илгээхэд хүннүгийн Хэлянь Бобосин замаас нь булаан авсан байна. (14-ийн 58). 411 онд Хулюй хаан умард Янь улсын хаан Фэн Бад 3000 морь бэлэглэсэн. (14-ийн 54). 434 онд Нируны Ути хаан табгачийн хаантай ураг барилдахдаа 2000 морь бэлэглэсэн (10-ын 14; 16-ын 273, 271) байна. 515 онд Нирун улс Өмнөд Хятадын Лян улсад элчин илгээн, морь, булган дах барьсан. (10-ын 43; 16-ын 290). 533 онд Анагуй хаан табгачийн Вэй улсаас гүнж авах сүйд 1000 морь бэлэглэсэн. (10-ын 33; 16-ын 288). 541 онд Нирун улс Өмнөд Хятадын Лян улсад нэг жин алт, нэг морь бэлэглэсэн. (10-ын 43; 16-ын 290). Анагуй хаан 541 оны 4-р сард Зүүн Вэй улсын гүнжийн сүйд 1000 морь илгээсэн (10-ын 35; 16-ын 293) байна. Нирун улс 407—541 онд харь улсад долоон удаа мориор сүй, бэлэг барихдаа 8000—10000 морь бэлэглэх байсан нь нэг талаар адуу олонтой, нөгөө талаар морь эрхэмлэх байсны гэрч, Өмнөд Хятадад байсан Лян улсад ганц морь бэлэглэж байсан нь алс хол учир ганц сайн хүлэг өгч байсан хэрэг. Цаашилбал 429 онд табгачийн Шицзу хаан гурван замаар Нирун улсыг довтлохдоо сая гаруй цэргийн агт дээрэмдсэн (10-ын 12; 16-ын 273). Вэй улсын цэрэг 443 онд Нирун улсыг довтлохдоо хоёр түм гаруй морь дээрэмдсэн (10-ын 131) Табгачийн Вэй улс 454 онд өвлийн 11-р сард Нируныг довтлож, 1000 гаруй морь дээрэмдэн авчээ. (10-ын 150; 14-ийн 68). Табгачийн Вэй улсынхан Нирун улсыг олон удаа довтлохдоо зөвхөн

нэг удаа сая гаруй адуу дээрэмдэж байсан нь Нирун улс адуу асар олонтой байсны гэрч. Нирун улсын малын тун багцаалсан тоо, сүргийн бүрэлдэхүүнийг үзэхэд тэр нь нэг талаар хүннүгээс уламжлалтай, нөгөө талаар хожмын монголчуудад өвлөгдсөн нь тодорхой байна.

**Цагаан идээ.** Нируны Анагуй хаан 523 оны 4-р сард табгачийн Вэй улсын элчнийг саатуулан айраг (лао) өгч байснаас өөр нирунчуудын цагаан идээний тухай мэдээ сурвалж бичигт байхгүй. Гэвч нэг талаар бүр хүннүгийн үед тараг, ааруул, бяслаг, айраг гэх мэтийн үндсэн төрлийн цагаан идээ байсан болохоор нирунчууд бас үндсэн төрлийн цагаан идээтэй байсан гэж үзэж бүрэн болно.

**Тэрэг.** Нирунчууд Монгол орны нүүдэлчид мөн болохоор тэрэг олноор хэрэглэдэг байснаас гадна янз янзын тэрэгтэй байв. Табгачийн Вэй улс 429 онд Нирун улсыг довтлон, асар олон тэрэг дээрэмдэжээ (12-ын 102). 538 онд Анагуйн ууган охин табгачийн Баруун Вэй улсын хааны хатан болон очиход 700 тэрэг хэрэглэсэн байна (10-ын 50; 17-гийн 68; 8-ын 72). 429 оны мэдээгээр нирунчууд мухлаг тэрэг<sup>1</sup> (кэчэ) хэрэглэж байв (10-ын 104). Гэр тэргэнтэй байжээ. Нирунчууд тэргэнд чухам ямар мал хөллөдөг байсан тухай мэдээ байхгүй боловч, эртний ба хожуу үеийн нүүдэлчдийн адил зүтгэх хүчний мал болох морь, үхэр, тэмээг тэргэнд хөллөдөг байсан нь мэдээж. Тэрэгний талаар нирун, монголчуудын хооронд залгамж холбоос байна. Монголын нууц товчооны 6, 64, 101, 124-р зүйлийн мэдээгээр тэнгэлэгтэй тэрэг, цуургатай тэрэг, хагатай тэрэг, хасаг тэрэг, харуутай тэрэг, өлжигтэй тэрэг гэх мэтийн хэдэн янзын тэрэг байгаа нь (9-ийн 13, № 3, 122, № 5, 236, № 64, 336, № 15, 18) эртний уламжлалтайн гэрч.

**Тариалан.** Нирунчууд хүннү зэрэг эртний нүүдэлчдийн нэгэн адил голын хөндийгөөр хар будаа зэрэг тарин, бага сага тариалан эрхэлж байсан бололтой.

Анагуй хаан 522 онд табгачаас тариалах хад будаа<sup>2</sup> түмэн дань<sup>3</sup> авч байжээ (10-ын 30; 17-ын 75; 16-ын 286). Энэ үед нирунчууд Мөөмт балгастай болсон байсан. Ингэхлээр хотынхоо ойролцоо тариалантай байсан байх. Нирунчуудын тариалангийн уламжлал XIII зууны үед язгуур монголчуудад уламжлагдан цааш хөгжсөн байна. Монголын нууц товчооны 257 зүйлийн мэдээгээр тариа эрхлэх хүнийг тариачин гэж нэрлэх тусгай нэр бий болжээ.

**Мөөмт хот.** Нирунчууд 502—519 оны үед Динлин нарыг бутцохиод, хэрэм хот (Чэн гоу)-г эхлэн байгуулжээ. (10-ын 43, 17-гийн 68; 16-ын 290). «Чэнгоу» гэдэг хятад үг хоёр давхар бэхлэлт хэрмээр хүрээлэгдсэн хотыг хэлдэг бөгөөд иймэрхүү хотыг Монголын нууц товчооны 203-р зүйлд юургат балгасан гэж нэрлэжээ (1-ийн 954; 19-ийн 116).<sup>5</sup> Ийм хотыг нэрлэх тусгай нэр Монголын нууц товчоонд байгаа болохоор нирун, хожмын монголчуудын хооронд энэ талаар залгамж холбоос байна.

Нирунчуудын энэ хот тусгай бэхлэлт хэрэмтэй хот байсан, нөгөө талаар Хятадууд өөрсдийн хэрэмт хотыг нэрлэх «Чэнгоу» гэдэг нэрээр нэрлэсэн болохоор захиргаа, гар урлалын төв болохуйц нэлээд том хот байсан бололтой. «Мумо» гэдгийн тэр үеийн дуудлагыг үзэхэд монгол хэлний «мөөмт» гэдэгтэй үндсэндээ дүйж байна. Уг хот чухам хаана байсан талаар сурвалж бичигт тодорхой дурдаагүй.<sup>6</sup> БНМАУ-ын түүхэнд Төв аймгийн нутагт Туул голын хөндий дэх өн-

гөтийн дурсгал гэгчийг жужаных (нируных) гэж бичжээ. (3-ын 123; 4-ийн 107). Сүүлийн үеийн судалгааны байдлаас дурдвал, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Туул голын хөндийд орших өнгөтийн хөшөө хэмээн нэрлэгдэх, эргэн тойрон шороон далан, усны татаал шуудуутай, дундаа тахилгын чулуун хайрцаг, 35 хүн чулуу, нэг чулуун арслан, 550 орчим талбай бүхий эртний иж бүрэн дурсгалыг монгол-зөвлөлтийн шинжилгээний анги шинжилжээ. (2-ын 3). Д. Баяр: а) түрэгийн үеийн хөшөөний өвөрмөц онцлог болох хувцас, зэвсэг, хавтга сав, гоёл чимэглэлийн зүйл өнгөтийн хүн чулуунд байхгүй байгаа; б) бүх хүн чулуу хоёр гараа элгэндээ зөрүүлсэн буюу ямар нэг сав барьсан мэтээр дүрслэгдсэн нь түрэгийн уламжлалаас өөр байгаа; в) дурсгалын талбайд рүн бичгийн дурсгал олдоогүй; г) чулуун арслан байгаа, эдгээр өвөрмөц талыг баримтлан, өнгөтийн дурсгалыг түрэгийн өмнөх үед, «магадгүй жужан улсын үед холбогдох дурсгал болов уу гэж үзнэ» гэжээ (2-ын 15).

Өнгөтийн дурсгал Нирун улсын үед холбогдох юм бол Мөөмт балгас байх ёстой. Гэтэл Мөөмт балгас мөн гэхэд бэрх байна, учир нь: а) балбал зэрэг түрэгийн уламжлалт дурсгал зонхилж байна; б) уг дурсгалын цар хэтэрхий бага байна. Д. Баярын дэвсгэр зургийн масштабаас үзэхэд ердөө 120 гаруй метр урт, 80 гаруй метр өргөн жижиг суурин бололтой. Нэлээд ултай шинжилгээ, нотолгоо шаардагдаж байна.

Нирунчууд Мөөмт хот гэх хэрэмтэй хот байгуулж байсан болохоор аль нэг хэмжээгээр хотын оршин суугчдыг хангах суурин газрын аж ахуй үүслийн чанартай ч гэсэн байсан гэж үзүүштэй.

**Гэрийн үйлдвэрлэл**, Монгол-Нирун улсынхан нүүдэлчид байсан болохоор гар урлал мал аж ахуйгаас тусгаарласан гэх баримт байхгүй. Мөөмт балгас гэх бэхлэлт хэрэмтэй хот буй болсон болохоор суурин газарт гар урлал бие даан эрхлэгчид байсан байх.

Түрүү үеийн ба хожмын монголчуудын адил Нирунчууд гэрийн үйлдвэрлэлийн хэлбэрээр гар урлал эрхлэн, хүнд морин цэргийн морины ба хүний хуяг, жад мэтийн зэвсэг, гэр тэргэн, сүйх тэрэг, гэр зэрэг гэр аж ахуйн зүйлсийг мод, төмөр, шир, арьс ноос мэтээр хийж байсан нь мэдээж. Чулохуй Татарыг хаан өргөмжлөнө гэж алтан хазаар явуулж байсан, өмнөд хятадын Лян улсад 541 онд алт илгээж байснаас (10-ын 27) үзэхэд нирунчууд алтаар гоёл чимэглэлийн зүйл хийдэг алтны дархантай байжээ. Нирун улс Табгачийн улсад бурханы сувдан хөрөг, хятадын өмнөд Ци улсад арсланы арьсан дээл бэлэглэж байснаас үзэхэд Дундад Ази, Хятад зэрэг газрын гар урлалын маш нарийн хийцний эдийг эдлэж байжээ.

Иймд нирунчууд харь орны нарийн урчуудыг урьж авчирч, өөрийн оронд нарийн гар урлал хөгжүүлэхийг оролдсон юм. Нирун улсын элчин 483 оны үед Хятадын Өмнөд Ци улсад очиж, оточ, бөс нэхэгчид, зүг заагч, усан цаг өхийг гуйсан байна. Чингэхэд оточ, бөс нэхэгчид, зүг заагч, усан цаг өгөх боломжгүй зүйл юм, яагаад гэвэл өмнөд нутагт өвчин анагаах нь умард зүгийнхээс өөр, харин бөс нэхэгчид цөм бүсгүйчүүд болохоор алс холын нутагт очих нь бэрх. Зүг заагч, усан цаг мэдэх хүмүүс эрт үед үгүй болсон. Иймд өршөөл гуйя гээд нирунчуудын хүссэн зүйлийг өгөөгүй байна (10-ын 42; 17 гийн 72; 8-ын 75). Нирунчуудын гар урлалын эл уламжлал хойшид залгамжлагдан хөгжсөн нь гэр, тэрэг, зэвсгийн зүйл, тэрчлэн харь

орны урлалын зүйлийг нэрлэх асар олон нэр Монголын нууц товчоонд байдгаас тодорхой харагдана. Жишээлбэл, Монголын нууц товчооны 135, 238, 249, 274-р зүйлд начид (алтан ширхэгтэй торго) дардас (дардан торго), агурсун (хоёр өнгийн ёнхороор ор дэвсгэрийг ялгаруулан нэхсэн таж торго), өрмөг (ноосон эд), торго гэх харь орны гаралтай торго, бөсийн нэр байна. (9-ийн 371, № 5, 769, № 6, 770, № 7, 820, № 12). Эдгээр нэр Монголын нууц товчоог 1240 онд зохиох үед буй болоогүй, эртний уламжлалтай нь мэдээж.

**Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй.** Нирунчуудын аж ахуй сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй байжээ. Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй Хүннү улсын (МЭӨ 209 он МЭӨ I зуун) үед бүрэлдэн тогтож, хөгжин боловсорсоор эдүгээ хүрчээ. Монгол орны нийгэм-эдийн засаг, соёлын ба хүн амын гол хэрэгцээг хангаж, тийм хэрэгцээг бий болгож чаддаг, Монголын өвөрмөц нүүдлийн мал аж ахуйг сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэж нэрлэж байна. Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэдэг нэрийг Монгол орны газарзүй-цаг уурын өвөрмөц нөхцөлтэй шууд уялдуулан авч үзэж байна. Энэ бол Төв Азийн нүүдэлчдийн иргэншлийн нэг хэсэг юм. Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал, аж ахуй гэж уламжлалт цогцолбор шинжээр нь нэрлэж байна. Үүнд: 1. Монгол орны газарзүй-цаг уурын онцлог нөхцөлд олон үеийн турш малыг шалгаруулан авах ардын уламжлалт аргын үндсэн дээр буй болсон монгол үүлдрийн таван хошуу мал;

2. Монгол орны газарзүй-цаг уурын ерөнхий байдалд зохицуулан, нутаг нутгийн онцлогтой уялдуулсан таван хошуу малыг төрөл тус бүрээр нь маллах өвөрмөц технологи;

3. Сүргийн бүрэлдэхүүн:

4. Мал аж ахуй, экологийн зохистой уялдаа;

5. Малын бэлчээрийг сонгох, хуваарилах, ашиглах журам;

6. Малаа арчлах, хамгаалах, үржүүлэх цогцолбор арга ухаан;

7. Саахалт, хот айл, гэр бүлийн доторхи хөдөлмөрийн хуваарь;

8. Бод малыг уналга, хөллөгөө, ачлаганд ашиглах журам, технологи

9. Малын үс, ноос, арьс, шир, мах мэтийн түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, ашиглах, хадгалах технологи;

10. Таван хошуу малын сүүг саах, боловсруулах, ашиглах, хадгалах технологи;

11. Малын эдэлгээтэй холбогдсон цогцолбор төхөөрөмж, тоног хэрэгсэл (тэрэг, эмээл, хом, сур, дээс гэх мэт);

12. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, хадгалах иж бүрэн сав, хэрэгсэл;

13. Малын бие махбодь, авир, зангийн тухай үе улирсан эрдэм ухаан;

14. Мал аж ахуйтай холбогдсон олон зүйлийн зан үйл, заншил;

15. Нүүдлийн мал аж ахуйтай шууд уялдаатай өвөрмөц сууц-гэр;

16. Монголын мал аж ахуйтай шүтэлцээтэй гэрийн үйлдвэрлэл, мөн цөөн суурин, хот, жижиг тариалан байсан эдгээр болно.

Түрүү үеийн нүүдэлчдийн, Монгол-нирунчуудын аж ахуйг систем аргын үндсэн дээр харьцуулан задлан шинжлэж нэхэн сэргээх замаар сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэж үзэж байна. Монголын нууц товчоо зэрэг монгол, хятад, перс гэх мэтийн олон хэлний

сурвалж бичгийн мэдээг задлан шинжлэхэд дээр дурдсан сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуйн шинжүүд XIII зууны монголчуудын аж ахуйд тод харагдаж байна. Хүннүгийн талаархи хятад сурвалж бичгийн мэдээ арвин, нөгөө талаар хүннүгийн тухайд археологийн олдвор нэлээд сайн судлагдсан болохоор хүннүгийн аж ахуй сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй мөн болохыг тогтооход харьцангуй хялбар байв (5-ын 19—52).

Монгол Нирунчуудын аж ахуйг ямар баримтын үндсэн дээр сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэсэн бэ? гэвэл;

1. Хятад сурвалж бичгийн лавтай мэдээгээр хүннү сүмбэ (сяньби), нирунчуудын улс Монгол оронд бие биесээ залгамжлан тогтсон болохоор аж ахуйн хөгжлийн ямар нэг ухралт байхгүй;

2. Нийгэм-эдийн засаг, соёл, угсаа гарвалын залгамж холбоос хүннү, нирунчуудын хооронд байна;

3. Нирунчуудын тухай хятад сурвалж бичгийн мэдээгээр нирунчуудын аж ахуйг дээр нэхэн сэргээсэн байвал;

4. Монгол-Нирун улсын нийгэм нэгэн бүхэл организм-систем мөн болохоор аж ахуй нь бүхэл системийн нэг бүрдүүлэгч;

5. Монгол-Нирунчууд хожмын Монголчуудын хоорондын угсаа гарвалын холбогдол (6-ын 76—78), эдгээрээс үзэхэд нирунчуудын аж ахуй сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй мөн.

Монголын сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй бол хөдөлмөр зарцуулалт, өгөөж, экологийн хувьд их үр ашигтай аж ахуй юм. Гэтэл энэ аж ахуйд тариалан төвийн үзлийн (агроцентризм) үүднээс (5-ын 15, 16, 47, 151) хандаж, эрчимгүй (экстенсивный) аж ахуй гэх эдийн засгийн ухааны ухагдахуун хэрэглэн, улмаар эл аж ахуйг суурьшмал орны тариалангийн аж ахуйтай зохиомлоор жишиж, үүний үндсэн дээр Монгол орны нүүдэлчдийн нийгэм-аж ахуйн хөгжлийг басамжлах хандлага эрдэмтдийн бүтээлд байсаар байна. Эрчимтэй (интенсивный), эрчимгүй (экстенсивный) гэх эдийн засгийн ухааны ухагдахуун нь эдийн засгийн хөгжлийн маягийг тодорхойлоход (16 а-гийн 73) хэрэглэгддэг болохоор аж ахуйн шинжинд холбогдохгүй. Ер нь нүүдлийн мал аж ахуй, тариалангийн аж ахуйн аль алин нь орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололт хэрэглэхээс өмнө ерөнхийдөө эрчимгүй аж ахуй байсан билээ. Нийгмийн үйлдвэрлэл аж ахуйн хамгийн гол шинжийг харуулах, эдийн засгийн ухааны түлхүүр (гол) ай болох үр ашиг (эффективность) гэдэг ухагдахууныг (16 а-гийн 56, 73; 20-ын 43) хэрэглэх нь зүйтэй «Эрчимгүй» гэдэг эс оносон ухагдахуун, нүүдлийн мал аж ахуй ер нь түүхэнд хэрэглэсний улмаас Монгол орны нүүдэлчдийн нүүдлийн мал аж ахуй, түүнтэй шүтэлцсэн нүүдлийн нийгэм-соёлын асуудлыг ташаа тавих нь олонтой байна. Тариалан төвийн үзэлт судлаачид суурьшмал орны олон түмний амьдрал Монгол орны нүүдэлчдийнхээс илүү сайн байсан мэт бичсэн нь олонтоо буй. Түүхэн үнэн байдал тийм бус. Гадаад орны эдийн засгийн ухааны нэлээд нэр хүндтэй номд бичихдээ: «Аль нэг хэмжээгээр давуу байдалтай орон болох Францад нийтийн өлсгөлөн X зуунд 10, XI зуунд 26, XII зуунд 2, XIV зуунд 4, XV зуунд 7, XVI зуунд 13, XVII зуунд 11, XVIII зуунд 16 удаа тус тус болсон гэж тооцоолсон билээ. Иймэрхүү зүйлийг европын аль ч орны хувьд хэлж болно» гэжээ. (20-ын 118). Хөрш Хятад орны түүхэнд нийтийн өлсгөлөнгийн тухай мэдээ арвин буй. Жишээлбэл, хятадын Баруун Цзинь

улсын Хуй-ди хааны (290—306 он) үед «газар бүр өлсгөлөн болж, ард түмний олонхи нь турж үхсэн байна» гэж (13-ын 538) орчин үеийн Хятадын түүхчид бичиж байна.

Монголын нүүдэлчдийн дунд өлсгөлөн болсон тухай мэдээ Хятад, сурвалж бичигт маш ховор байдаг. 523 онд Нируны Анагуй хааны хүмүүс их өлсгөлөн болж табгачийн Вэй улсын хилээр дээрэм хийсэн гэх ганц мэдээ (10-ын 30; 16-ын 286) Нируны талаар байна, гэхдээ турж үхсэн тухай дурьдсангүй.

Монгол-Нирун улсын энэ аж ахуй нь түрүү феодализмын шатанд шилжин орсон тэдний нийгмийн хөгжилтэй тохирч байна.

### Тайлбар

1. «Кэчэ» гэдгийн «кэ» нь хүнхэр, нүх гэх утгатай «чэ» нь тэрэг гэсэн үг, ингэхлээр мухлаг тэргийг хэлжээ.
2. «Су» хар будаа, Hirse юм.
3. «Дань» гэсэн хятад хүндийн хэмжүүр нь 103, 54688 метртэй тэнцэнэ. Түмэн дань нь 720 тонн гэж А. Коллауц, Х. Миякава нар үзжээ, (17-гийн 75).
4. «Чэнгоу» гэдгийг В. С. Таскин гадаад дотоод хэрэмтэй хот гэж, А. Коллауц, Х. Миякава нар бэхлэлт хот гэж орчуулжээ. (16-ын 290, 17-гийн 68).
5. Монголын нууц товчоонд хэрэм хотыг нэрлэх нэрийг Баяр, Рахевильз, Э. Хэйниш нар «юургат балгасан» гэж хоорондоо ерөнхийдөө төстэй галиглажээ (1-ийн 954, 19-ийн 116, 18-ын 171).
6. Манж Чин улсын газарзүйч Дин Пянь (1843—1919 он) хүннүгийн ордон байсан нутгийг нирунчууд эзэлсэнийг үндэс болгон, хүннүгийн ордон Сайнноён хан аймгийн Тамирын голоос хойш байсан болохоор нируны хот тэнд байх ёстой гэж таажээ (11-ийн 1713, № 2). Г. Утида «мумо» гэдгийг «мулай» гэдгийн ташаарал байх гээд, Ордосоос хойш Газал (Инь шань) уулаас баруунтийш байдаг. Мулай шань уул байх гэж үзжээ (15-ын 260, № 4). Нотолгоо байхгүй. Ташаарал гэх ямар ч баримт байхгүй. Нирун улс БНМАУ-ын нутгаар төвлөн байсан болохоор Мөөмт Орхон, Туул зэрэг голын саваар байх ёстой. Тамир сумын нутагт урд Тамирын голоос хойш Их, бага Өргөөгийн тэнд байдаг хоёр Мөөм толгойн орчмын хуучин балгасны суурь гэж таамаглахыг оролджээ (7-ийн 178—179). Цаашид археологийн маш нарийн судалгаа хийж шийдэх ёстой.

### Ном зүй

1. Баяр. Монголын нууц товчоон. Гурван дэвтэр. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо Хөх хот, 1981 (хуучин монголоор)
2. Д. Баяр. Туулын хөндий дэх түрэгийн өмнө үеийн хүн -Studia Archaeo-Logica Instituti Historiae Academiae Scientiarum Reipublicae Populi Mongolici, Tomus VII ass Археологийн судлал УБ. 1979 3—22-р тал
3. БНМАУ-ын түүх. Нэмж засварласан гуравдахь хэвлэл, УБ., 1984,
4. Саган Сэцэн, Эрдэнийн товч (хуучин монголоор). УБ., 1961
5. Г. Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг. УБ., 1980
6. Г. Сүхбаатар. Жожань, Нирун хоёр нэгэн нэр болох тухай, — «БНМАУ ШУА-ийн мэдээ», 1988, №1, 76 87-р тал
7. Ц. Хандсүрэн, Жужаны түүхийн зарим асуудал. -Эрдэм шинжилгээний өгүүлүүд. УБ, 1968. 173-197-р тал

8. Ц. Хандсүрэн. Жужаны аж байдал, соёл, зан заншлын тухай Түүхийн судлал, УБ., 1969, 67—80-р тал
9. Элдэндэй, Ардажав. Монголын нууц товчоон сийрүүлэл тайлбар. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986. (хуучин бичгээр)
10. Жоужань цзыляо цзилу (Нируны тухай материалын эмхтгэл) Бээжин., 1962.
11. Лидай гэцзу чжуань цзи хуйбянь, Диэрбянь ся цэ (Түүхэн турш дахь угсаатны тухай тусгай тэмдэглэлийн эмхэтгэл), 2-р боть, доод дэвтэр. Шанхай, 1959.
12. Чжунго гудай бафан гэцзу цзяньши (Хятадын эртний умар зүгийн угсаатнуудын товч түүх). Хөх хот., 1979
13. Чжунго гудай ши (шан). Лю Цзэхуа, Ян Чжицзю, Ван Юйчжэ, Ян Исян, Фэн Эркан, Нань Бинвэнь бяньчжэ. Бээжин (Хятадын эртний түүх). 1979
14. Г. Утида, Хожуу Вэй улсын үеийн нируны он дараалсан үйл явдал, -Тоёши —Кэнкю, VIII, № 4, 1943. 51—72, 1—45-р тал.
15. Морьтон үндэстний түүх. 1. Токио, 1971, (японоор)
16. Материалы по истории древних кочевых народов группы дунху. Введение, Перевод и комментарии В. С. Таскина, Москва, 1984,
16. а. Политическая экономия Учебник для высших учебных заведений. Политиздат, Москва, 1988.
17. Arnuff Kollautz, Hisayuki Miyakawa. Geschichte und Kultur eines Völker-Wan derungszeitlichen Nomadenvolkes. Die Joujan der Mongolei und die Awaren in Mit teleuropa. I Teil. Die Geschichte. Bonn, 1970
18. Erich Haenisch, Wörterbuch ru Mandhol un Niuca Tobca'an (Yuan-ch'ao pi-shi) Ge heime Geschichte der Mongolian Wiesbaden, 1962
19. Index to the secret history of the Mongols. Igor de Rachewiltz. Bloomington, 1972
- 20 William J. Baumol, Alan S. Blinder. Economics. Principles and Policy, Fourth edition. Harcourt Brace Jovanovich, Publishers, San Diego, New York, Chicago, Austin, Was hington D. C. , London, Sydney, Tokyo, Toronto, USA, 1988.

**МОНГОЛ-ХЯТАДЫН ХАРИЛЦААГ ХЭВИЙН БОЛГОХ  
ТАЛААР МАХН, АРДЫН ЗАСГИЙН ГАЗРААС  
ХЯТАДЫН ХУВЬСГАЛТ ДЭВШИЛТ ХҮЧИНТЭЙ  
ХАМТРАН ТЭМЦСЭН НЬ  
(1925—1931 он)**

**Р. Отгон**

Монголын ардын засгийн газар гадаад байдлаа бэхжүүлэх, юуны өмнө хөрш зэргэлдээ орон Хятадтай харилцаагаа хэвийн болгоход их анхаарал тавьж байв. Гэтэл хятадын харгис хүчин БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байснаас гадна хятадын цэргийн эрхтнүүд БНМАУ-ыг улс төр-эдийн засгийн талаар хяхан хавчихаа улам ихэсгэж түүний хил хязгаар дээр цэргийн үлэмжхэн хүчийг хуралдуулж байжээ. Энэ үед империалист Япон Монгол улсын хувьсгалт байгууллыг устгах, Монголыг эзлэн авч түүнийг ЗХУ-д дайран довтлох дайны талбар болгохыг эрмэлзэж байв. Ийнхүү хятад, Японы цэргийн эрхтнүүд шинэ тулгар Монгол улсын аюулгүй байдал,